

## **МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Ажилтны хөдөлмөр эрхлэхтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээнд заасан суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр ажиллах илүү таатай нөхцөлөөр хангах, нийгмийн хамгаалалтай холбоотой зарим асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх, ажил, амралтын цагийг зохицуулах, эрүүл мэнд, сургалтыг дэмжих, орон сууцны нөхцөлийг сайжруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ажилтны хүүхдэд ээлтэй бодлого хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд энэхүү хөтөлбөрийг баримтална.

### **ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО**

2.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажиллах нөхцөлийг үе шаттай сайжруулах, орон сууцны нөхцөл, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалах зэрэг нийгмийн баталгааг хангах, улмаар Компанийн бизнесийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэхэд оршино.

### **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **3.1. Ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах чиглэлээр:**

3.1.1. Ажилтны амьдрах орчин нөхцөлөө сайжруулах, орон сууц, гэр, хашаа байшин, худалдан авах, шинээр барих, засварлах, орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь зориулж санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

3.1.2. Ажилтныг Засгийн газрын бодлого, шийдвэрийн дагуу хэрэгжүүлж байгаа түрээслээд өмчлөх болон түрээсийн орон сууцанд хамруулах асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, хамтран ажиллах.

#### **3.2. Ажилтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:**

3.2.1. Эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах.

3.2.2. Ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх эрүүл мэндийн ажилтныг ажиллуулах, шаардагдах тоног төхөөрөмж, өрөө тасалгааг үе шаттайгаар бий болгох.

3.2.3. Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг хамт олны дунд хэвшүүлэхтэй холбоотой ажилтны санал санаачилгыг санхүүгийн болон зохион байгуулалтаар дэмжин хамтран ажиллах.

3.2.4. Урлаг, спортын уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулах

### **3.3. Ажилтны сурч, хөгжих боломжийг бүрдүүлэх чиглэлээр:**

3.3.1. Мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургахад дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах.

3.3.2. Компанийн захиалгаар үндсэн ажлаасаа чөлөөлөгдөн гадаад, дотоодын сургалтад хамрагдаж буй ажилтанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

3.3.3. Өөрийн санаачилгаар мэргэжил эзэмших, мэргэшлийн зэрэг ахиулах сургалтад хамрагдаж байгаа ажилтныг дэмжиж, ажлын уян хатнаар шийдвэрлэх, цалинтай чөлөө олгох.

### **3.4. Ажилтны гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр:**

3.4.1. Ажилтанд гэр бүл, хүүхдэдээ зориулах цагийг нэмэгдүүлэх ажлын цагийн уян хатан бодлого хэрэгжүүлэх.

3.4.2. Ажилтан шинээр гэр бүл болох, компанийн ажилтнууд хоорондоо гэр бүл болсон тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

3.4.3. Ажилтны хүүхдийн өдөр өнжүүлэх өрөөг бий болгох.

3.4.4. Ажилтны сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах.

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ**

### **4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.**

4.1.1. Хууль дээдлэх

4.1.2. Ажилтан бүрийг хамруулах

4.1.3. Ил тод нээлттэй байх

4.1.4. Бодитой, үр дүнтэй байх

### **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ**

5.1. Энэхүү хөтөлбөрийг 2022 оны санхүүгийн жилээс хэрэгжүүлж эхлэх бөгөөд 2032 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын хэмжээг компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөнд тусган батална.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай зардлыг өмнөх оны хэмжээнээс бууруулахгүй байх зарчмыг баримтална.

## **ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ**

6.1. Удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тухайлсан журмыг боловсруулан ажилтнуудын төлөөлөл болон үйлдвэрчний нэгдсэн хорооноос санал авч Гүйцэтгэх захирлаар батлуулж, хэрэгжилтийг компанийн хэмжээнд хангуулан ажиллана.

6.2. Дотоод аудитын асуудал хариуцсан нэгж нь хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Гүйцэтгэх захирал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороонд танилцуулна.

6.3. Стратеги төлөвлөлт хариуцсан нэгж нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө тухайн жилийн бизнес төлөвлөгөөний төсөлд тусган Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах ажлыг зохион байгуулна.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар компанийн удирдлага болон ажилтан, ажилтны төлөөлөл санал, хүсэлт гаргаж болох ба хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, ажилтны санал хүсэлтийг үндэслэн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт, оруулах саналыг нэгтгэн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг Удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хариуцна.

## **ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН**

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ажилтны хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэл нэмэгдэж, тогтвор суурьшилтай, урам зоригтой, чадварлаг сэтгэл ханамжийн баталгаатай хүний нөөц, бүрдэж, компанийн тогтвортой үйл ажиллагаа хангагдана.